БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/92/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70642580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн<br>Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


Товчилсон үгийн жагсаалт....................................................................................2
1.Аудитын тайлангийн дүгнэлт ..............................................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .........................................5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................................5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....................................................5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...............................7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.............................................................8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......................................................9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.........................................10
3. Аудитын тайлан...................................................................................................11
3.1 Ерөнхий зүйл ........................................................................................................ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .................................................... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ......................................................... 12
3.4 Материаллаг байдал ............................................................................................ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..................................................................... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..................................................... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......................................... 14
3.8 Аудитын гол асуудал ........................................................................................... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт......................................................... 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.......................................................................... 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал............................................................. 15
4. Аудитын илрүүлэлт ............................................................................................15
4.1 Залруулсан алдаа................................................................................................. 15
4.2 Төлбөрийн акт...................................................................................................... 15
4.3 Албан шаардлага ................................................................................................. 16
4.4 Зөвлөмж ............................................................................................................... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....................................................17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын тайлангийн дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2022.02.22 № 26

танай ______-ны № ______ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Ш.ЭНХЭЭ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

D:/bichighereg/2022A4toot

006020597

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,225,130.00** | **16,277,180.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,225,130.00 | 16,277,180.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,225,130.00 | 16,277,180.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 22,500.00 | 22,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,108,330.00 | 14,160,380.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,845,000.00 | 1,845,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 249,300.00 | 249,300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **114,000,268.93** | **101,111,020.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 114,000,268.93 | 101,111,020.15 |
| **392** | **Биет хөрөнгө** | 112,346,268.93 | 99,457,020.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 745,717,239.51 | 745,717,239.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (658,716,894.94) | (671,145,515.62) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 12,030,243.00 | 16,645,243.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,820,166.37) | (6,984,337.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,534,405.02 | 17,534,405.02 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,870,503.29) | (16,565,959.92) |
| 39217 | Ном | 14,471,946.00 | 14,255,946.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,654,000.00 | 1,654,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,654,000.00 | 1,654,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **130,225,398.93** | **117,388,200.15** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **130,225,398.93** | **117,388,200.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 130,225,398.93 | 117,388,200.15 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (76,797,947.01) | (89,635,145.79) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (76,797,947.01) | (76,797,947.01) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (12,837,198.78) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 129,280,194.66 | 129,280,194.66 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **130,225,398.93** | **117,388,200.15** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **133,856,593.00** | **140,540,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,661,843.00** | **1,095,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,661,843.00 | 1,095,700.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,351,843.00 | 1,095,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 930,700.00 | 1,095,700.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,421,143.00 | - |
| 120009 | Бусад орлого | 3,310,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **128,194,750.00** | **139,444,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,303,850.00 | 175,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,303,850.00 | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 126,890,900.00 | 139,269,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 126,890,900.00 | 139,269,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **143,958,022.91** | **153,161,498.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **143,958,022.91** | **153,161,498.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 107,041,461.91 | 138,367,132.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 66,075,434.00 | 45,074,167.00 |
| 210101 | Үндсэн цалин | 51,495,895.00 | 36,297,350.00 |
| 210102 | Нэмэгдэл | 14,579,539.00 | 8,776,817.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,763,109.00 | 5,846,234.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,048,561.00 | 4,050,273.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 611,719.00 | 441,191.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 666,973.00 | 353,229.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 130,497.00 | 88,457.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,305,359.00 | 913,084.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,700,921.00 | 65,807,453.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 665,161.00 | 551,068.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,035,760.00 | 65,256,385.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 262,340.00 | 1,106,260.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 78,000.00 | 84,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 119,640.00 | 99,810.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 89,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 64,700.00 | 757,650.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,800.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 44,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,212,920.00 | 1,061,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 88,950.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,123,970.00 | 981,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 68,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 68,000.00 | 56,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,213,525.00 | 2,127,770.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,105,525.00 | 1,111,250.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 16,520.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,700,412.91 | 17,288,248.78 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,700,412.91 | 17,288,248.78 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,916,561.00 | 14,794,366.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,373,753.00 | 13,492,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,619,300.00 | 13,292,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 754,453.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 15,542,808.00 | 1,301,766.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,542,808.00 | 1,301,766.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(10,101,429.91)** | **(12,621,198.78)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 24,458.99 | 216,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 24,458.99 | 216,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (24,458.99) | (216,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(10,125,888.90)** | **(12,837,198.78)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бус ад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 77,743,151.28 | 129,280,194.66 | (66,672,058.11) | | 140,351,287.83 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **77,743,151.28** | **129,280,194.66** | **(66,672,058.11)** | **-** | 140,351,287.83 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (10,125,888.90) | | (10,125,888.90) |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **77,743,151.28** | **129,280,194.66** | **(76,797,947.01)** | **-** | 130,225,398.93 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **77,743,151.28** | **129,280,194.66** | **(76,797,947.01)** | **-** | 130,225,398.93 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **77,743,151.28** | **129,280,194.66** | **(76,797,947.01)** | **-** | 130,225,398.93 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,837,198.78) | | (12,837,198.78) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **77,743,151.28** | **129,280,194.66** | **(89,635,145.79)** | **-** | 117,388,200.15 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **129,125,450.00** | **140,540,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **930,700.00** | **1,095,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 930,700.00 | 1,095,700.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 930,700.00 | 1,095,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 930,700.00 | 1,095,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **128,194,750.00** | **139,444,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,303,850.00 | 175,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,303,850.00 | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 126,890,900.00 | 139,269,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 126,890,900.00 | 139,269,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **129,125,450.00** | **140,540,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **129,125,450.00** | **140,540,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **92,208,889.00** | **125,745,934.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 66,075,434.00 | 45,074,167.00 |
| 210101 | Үндсэн цалин | 51,495,895.00 | 36,297,350.00 |
| 210102 | Нэмэгдэл | 14,579,539.00 | 8,776,817.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,763,109.00 | 5,846,234.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,048,561.00 | 4,050,273.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 611,719.00 | 441,191.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 666,973.00 | 353,229.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 130,497.00 | 88,457.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,305,359.00 | 913,084.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,548,856.00 | 65,807,453.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 665,161.00 | 551,068.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,883,695.00 | 65,256,385.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 262,340.00 | 1,192,060.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 78,000.00 | 60,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 119,640.00 | 99,810.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 89,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 64,700.00 | 867,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,800.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 44,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 387,700.00 | 4,679,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,299,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 88,950.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 298,750.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 68,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 68,000.00 | 56,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,758,650.00 | 2,916,020.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,650,650.00 | 1,899,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 16,520.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,300,000.00 | 175,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,300,000.00 | 175,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,916,561.00** | **14,794,366.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,373,753.00 | 13,492,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,619,300.00 | 13,292,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 754,453.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 15,542,808.00 | 1,301,766.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,542,808.00 | 1,301,766.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 140,637,600.00 | 139,063,534.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 140,637,600.00 | 139,063,534.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 127,145,000.00 | 125,570,934.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 46,017,800.00 | 45,074,167.00 |
| 210101 | Үндсэн цалин | 38,158,700.00 | 36,297,350.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,859,100.00 | 8,776,817.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,212,400.00 | 5,846,234.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,371,700.00 | 4,050,273.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 460,200.00 | 441,191.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 368,100.00 | 353,229.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 92,000.00 | 88,457.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 920,400.00 | 913,084.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,975,800.00 | 65,807,453.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 665,300.00 | 551,068.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,310,500.00 | 65,256,385.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,193,000.00 | 1,192,060.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 | 60,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | 99,810.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,000.00 | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 90,000.00 | 89,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 868,000.00 | 867,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,680,000.00 | 4,679,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,300,000.00 | 4,299,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 80,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 58,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 58,000.00 | 56,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,008,000.00 | 2,916,020.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,900,000.00 | 1,899,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | 16,520.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,492,600.00 | 13,492,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,492,600.00 | 13,492,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,292,600.00 | 13,292,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 140,655,600.00 | 140,365,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 139,269,600.00 | 139,269,600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 139,269,600.00 | 139,269,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,386,000.00 | 1,095,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,386,000.00 | 1,095,700.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,303,850.00** | **175,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,303,850.00** | **175,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,300,000.00 | 175,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,300,000.00 | 175,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,300,000.00 | 175,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,850.00** | **-** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 3,850.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,303,850.00 | 175,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,303,850.00 | 175,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,303,850.00 | 175,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хишиг-Өндөр сумын Соёлын төв нь соёлын өвийг эрэн сурвалжилж, өвлүүлэн уламжлуулж, иргэдийнхээ хүсэл эрмэлзэлд нийцсэн цаглашгүй арвин өв сангаар үйлчилэн, урлагийн мэдрэмжийг дээшлүүлж, авьяаслаг хүмүүнийг тодруулна гэсэн зорилтыг тодорхойлжээ.

Хишиг-Өндөр сумын үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Ард иргэдэд соёлын үйлчилгээний хүртээмж ,чанарыг дээшлүүлж хүргэх;
- Ардын авъяастны идэвхи санаачлагыг өрнүүлж, ур чадварыг хөгжүүлэх;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 143,982.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,159.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1,619.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хишиг-Өндөр сумын Соёлын төв нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,837.2 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн  данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | | | |
| **Авлага** | | | |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 16,225.1 | 16,277.1 | 52.0 |
| **Үндсэн хөрөнгө** | 114,000.3 | 101,111.1 | -12,889.2 |
| **Нийт хөрөнгө** | 130,225.4 | 117,388.2 | -12,837.2 |
| **Өр төлбөр** | | | |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 130,225.4 | 117,388.2 | -12,837.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 130,225.4 | 117,388.2 | -12,837.2 |

Бараа материалын дансны үлдэгдэл 16,277.1 мянган төгрөг болж 52.0 мянган төгрөгөөр 52.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 2,136.7 мянган төгрөгийн аж ажуй материал худалдан авснаас 2,084.6 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 795,806.8 мянган төгрөг болж 4,399.0 мянган төгрөгөөр өссөн нь ардын хөгжмийн зэмсэг бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 2-ний өдрийн А/14 тоот тушаалаар 216.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 117,388.2 мянган төгрөг болж 12,837.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,683.7 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байгаа нь урсгал зардлын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 9,203.5 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Энэ нь 1 албан хаагч тэтгэвэрт гарахад төрөөс олгодог нэг удаагийн тэтгэмжийг олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 148,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 8,262.4 мянган төгрөгөөр бууруулан 140,637.6 мянган төгрөгөөр баталсан байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 140,637.6 мянган төгрөгийн төсөв батлалснаас 139,269.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,386.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 139,269.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,095.7 мянган төгрөг, нийт 140,365.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 139,063.5 мянган төгрөгийг зарцуулж 1,301.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Иргэдээс өгсөн хандив 175.0 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 175.0 мянган төгрөгийг зардалд зарцуулж 6,777.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**3.8 Аудитын гол асуудал**

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 112 мэдээлэл оруулахаас 112 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 1 мэдээллийн хугацаа нь болоогүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн;
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөл акт, албан шаардлага, зөвлөмж хүргэглээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 705.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 705.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Бүтэц орон тоо, тайлант оны батлагдсан төсөвт тусгагдаагүй 1 албан хаагчийн цалингийн зардалд 705.6 мянган төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Дотоод хяналттай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журамыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

“Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу байгууллагын дотоод хяналтын журамыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хишиг-Өндөр сумын ЗДТГ | 1 | 705.6 | | | 1 | 705.6 | | | | |